

МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Дүрмийн зорилго

1.1.Энэ дүрмийн зорилго нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн ангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн үүрэг, бүтэц зохион байгуулалт, сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

Хоёр. Дүрмийн үйлчлэх хүрээ

2.1.Энэ дүрэм нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гамшгаас хамгаалах алба, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн дэргэд байгуулсан мэргэжлийн ангийн харилцаанд үйлчилнэ.

2.2.Мэргэжлийн анги гэж гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д зааснаар ойлгоно.

2.3.Мэргэжлийн ангийг гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т зааснаар бүрдүүлнэ. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд томилогдсон иргэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай болон ажил үүргээс чөлөөлөгдсөн үед орлон ажиллах иргэнийг тогтмол тодотгон томилж, бэлтгэл бэлэн байдлыг хангасан байна.

2.4.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2-т заасныг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар, 33 дугаар зүйлийн 33.1.4, 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэгт заасныг үндэслэн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тус тус мэргэжлийн ангийг байгуулна.

2.5.Мэргэжлийн ангийн сургалтыг гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т заасны дагуу тухайн шатны Засаг дарга, 33 дугаар зүйлийн 33.1.4, 34 дүгээр зүйлийн 34.2.4-т заасны дагуу гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлага тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулж, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгоно.

2.6.Гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааны онцлог, хүчин чадалд нийцүүлэн мэргэжлийн ангийн зохион байгуулалт, хүн хүч, техник хэрэгслийн тоог тогтоож энэхүү дүрэмд зааснаас гадна бүлэг, хэсгийг нэмж байгуулж болно.

2.7.Мэргэжлийн анги нь тухайн шатны Засаг дарга, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын шийдвэрээр гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, эмнэлгийн тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлж оролцоно.

2.8.Мэргэжлийн ангид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохицуулалтаар хангах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

2.9. Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох, чиглэл өөрчлөгдөх тохиолдол нь тухайн мэргэжлийн ангийг татан буулгах, өөрчлөх үндэслэл болох бөгөөд хуулийн этгээд нь үйл ажиллагаа дуусгавар болсон талаар аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

Гурав. Мэргэжлийн ангийн зориулалт

3.1.Мэргэжлийн ангийг зориулалтаар нь "ерөнхий" болон "тусгай" гэж ангилна.

3.2.Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги нь эрэн хайх, аврах, гал түймэр унтраах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, түр орон байраар хангах, санхүү зохицуулалтын, хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах, нүүлгэн шилжүүлэх, байр зүйн зургийн, зарлан мэдээллийн, мэдээлэл, сурталчилгааны бүлгүүдтэй байна.

3.3.Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэг.

№	Бүлэг	Хэсэг	Чиг үүрэг
---	-------	-------	-----------

1.	Эрэн хайх, аврах, гал түймэр унтраах бүлэг	Эрэн хайх, аврах хэсэг	Төөрсөн, сураггүй болсон, гамшгийн голомтод осолдогчийг эрэн хайх ажиллагааг зохион байгуулах
		Гал түймэр унтраах, аврах, хэсэг	Ой хээрийн болон объектын гал түймрийг унтраах, тархалтыг зогсоох, иргэдийг аврах хамгаалах
2.	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүлэг	Анхны тусламжийн хэсэг	Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах
		Хээрийн эмнэлэг дэлгэх хэсэг	Хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий л төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах
3.	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүлэг	Нийтийн хэв журам хамгаалах хэсэг	Гамшиг, ослын үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, эрэн хайх, аврах ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорио цээрийн дэглэмийн үеийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг бусад хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах
		Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэсэг	
4.	Түр орон байраар хангах бүлэг	Түр байраар хангах хэсэг	Түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, цэвэр ус, хоол хүнс, хөнжил, дулаан хувцас, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, аюулгүй байдал)-г хангах арга хэмжээг зохион байгуулах /1-7 хоног байрлах/
		Түр амьдрах байраар хангах хэсэг	Гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед хүн амын түр амьдрах байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах /7-14 хоног амьдрах/
5.	Санхүү, зохицуулалтын бүлэг		Гамшиг, ослын үед санхүү, хөрөнгө гаргах, зохицуулалт хийх, зохион байгуулах
6.	Хүнс, ус, дулаан хувцас, шатахуунаар хангах бүлэг		Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг хоол, цэвэр ус, хүнсээр хангах
7.	Нүүлгэн шилжүүлэх бүлэг		Гамшиг, ослын голомтоос нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулах шаардлагатай хүн, хүч, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх, зам маршрутыг тодорхойлох,
8.	Байр зүйн зургийн бүлэг		Гамшгийн үед бүх төрлийн хариу арга хэмжээний байр зүйн зургаар хангах, зураг хөтлөх.
9.	Зарлан мэдээллийн бүлэг		Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэртээ зарлан мэдээлэл дамжуулах
10.	Мэдээлэл, сурталчилгааны бүлэг		Гамшиг, ослын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр хангах, гамшгийн үед иргэдэд ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах

3.4.Тусгай зориулалтын мэргэжлийн анги нь байгууллагын онцлог, чиг үүрэг, үйл ажиллагаанд нийцсэн аюулгүй байдлын, нийгмийн хамгааллын, эрчим хүч сэргээх, бүртгэл мэдээлэл, статистик судалгааны, санхүү зохицуулалтын, нөөцийн бараа материал бүрдүүлэх, хүнс, усаар хангах дэмжлэгийн, олон улсын хүмүүнлэгийн тусламж зохицуулалтад дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ, усны сан бүхий газар, уст цэг, усан хангамжийн бүлэг, хөдөө аж ахуйн, зам, гүүр засварын, инженер, техникийн, холбооны техник хэрэгслийн засварын, харилцаа холбоо, мэдээллийн технологийн, цацраг, хими, биологийн хариу арга хэмжээ, хяналтын, тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй байдлын, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, зам, гүүрний засварын, автотээврийн хангалт, төмөр замын, нисэх буудлын аюулгүй байдлын, улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хамгаалах, харуул хамгаалалтын бүлэг, барилга байгууламж, дэд бүтцийн хяналтын, хот хаягдал цэвэрлэх, тээвэрлэх бүлэгтэй байна.

3.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн дарга нь тусгай зориулалтын мэргэжлийн ангийг бүлэглэн зохион байгуулахдаа гүйцэтгэх үүргийн онцлогт нийцүүлэн чиг үүргийг тодорхойлж, төлөвлөх бөгөөд үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохируулан байгуулна.

3.6.Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн чиг үүрэг

№	Бүлэг	Хэсэг	Чиг үүрэг
1.	Аюулгүй байдлын бүлэг	Тусгай зориулалтын хэсэг	Терроризмтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих, ухуулга, сурталчилгаа хийх
		Замын хөдөлгөөн зохицуулах хэсэг	Гамшгийн голомтод тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, журамлах
2.	Нийгмийн хамгааллын бүлэг	Хүүхэд хамгааллын хэсэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах
		Өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгааллын хэсэг	Гамшиг, ослын үед өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамжийн асуудлыг зохион байгуулах, голомтын бүсээс эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
3.	Эрчим хүч сэргээх бүлэг	Дулааны шугам сүлжээний засварын хэсэг	Дулаан, эрчим хүчний системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
		Цахилгаан сүлжээний засварын бүлэг	Гамшиг, ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц, шугамд гарсан эвдрэл гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
4.	Бүртгэл мэдээлэл, статистик судалгааны бүлэг	Иргэний бүртгэл, мэдээллийн хэсэг	Гамшиг, ослын үед иргэний бүртгэл, судалгаа хийх, мэдээ, мэдээлэл цуглуулах, хуулийн этгээд, иргэнд шаардлагатай лавлагаа, мэдээлэл гаргаж өгөх, бүртгэх
		Статистик мэдээллийн хэсэг	Мал амьтан, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн тооцоо болон бүх төрлийн судалгаа гаргах,

5.	Санхүү зохицуулалтын бүлэг	Санхүүгийн хэсэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр нөөц хөрөнгө бүрдүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө, зардлыг тооцох, шийдвэрлүүлэх
		Санхүүгийн нөөцийн хэсэг	Гамшиг, ослын үед санхүү, хөрөнгө гаргах, зохицуулалт хийх, зохион байгуулах
6.	Нөөцийн бараа материал бүрдүүлэх, хүнс, усаар хангах бүлэг	Хүнс, усаар хангах хэсэг	Нэрвэгдэгсэд болон гамшиг, ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг хоол, цэвэр ус, хүнсээр хангах
		Дулаан байр, хувцас хангалтын хэсэг	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсэд болон аврагч, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах
		Нөөц бүрдүүлэх хэсэг	Шаардлагатай хүнсний хангамжийг нөөцийг бүрдүүлэх
		Шатахуун, хийн түлш хангалтын хэсэг	Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэж байгаа автомашин, бусад техник хэрэгслийг шатах тослох материалаар цэнэглэх, хангах, нөөц бүрдүүлэх
		Агуулах, хангамжийн хэсэг	Бараа материал хадгалах агуулах, нөөц хадгалах байр бэлтгэх
7.	Олон улсын хүмүүнлэгийн тусламж зохицуулалтын бүлэг	Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн хэсэг	Нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм, журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
		Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн хэсэг	Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах
8.	Эрүүл мэндийн тусламжийн бүлэг	Цус сэлбэх хэсэг	Нэрвэгдэгсдийг цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээгээр хангах, нөөц бүрдүүлэх, тээвэрлэх, хүргэх ажлыг зохион байгуулах
		Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах хэсэг	Гамшиг, ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах
		Зоонозын өвчинтэй тэмцэх хэсэг	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомхотгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээ авах
		Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хэсэг	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн анхны тусламж, дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараах стрессийг бууруулах, сэтгэл гутралыг багасгах, хүмүүсийн даван туулах итгэл найдварыг сэргээх, бусадтай харилцах, холбоо тогтооход нь туслах Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн эрэн хайх, аврах ажиллагааны багийн гишүүдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх

9.	Усны сан бүхий газар, уст цэг, усан хангамжийн бүлэг бүлэг	Ус хангамж, ариутгах татуургын хэсэг	Цэвэр, бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх
		Усны сан бүхий газар, уст цэгийг хамгаалах хэсэг	Усны эх ундарга, усны сан бүхий газар, уст цэгийн бохирдолтод шинжилгээ хийх, усыг бохирдох, хор, халдвараас хамгаалах, ариутгал хийх, шинээр худаг ус гаргах, ус тээвэрлэх, түгээх, харуул хамгаалалтад авах, үер усны аюулаас хамгаалах
10.	Хөдөө аж ахуйн бүлэг	Ургамал, газар тариалан хамгаалах хэсэг	Химийн хоргүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, стандартын шаардлагыг хангуулах
		Ариутгал, халдваргүйжүүлэлтийн хэсэг	Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх
11.	Зам, гүүр засварын бүлэг	Зам, гүүр засварын хэсэг	Гамшгийн үед эвдэрсэн зам, гүүрийг засварлах, нөөц замыг тодорхойлох, гүүр дэлгэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
12.	Инженер, техникийн бүлэг	Инженерийн хэсэг	Гамшгийн үед бүх төрлийн инженерийн дэмжлэг үзүүлэх, тооцоолол гаргах
		Техникийн хэсэг	Техникийн дэмжлэг, засварын ажлыг гүйцэтгэх, бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн тооцоо судалгаа гаргах, техник хэрэгслээр хангах
13.	Холбооны техник хэрэгслийн засварын бүлэг		Гамшиг, ослын голомтод холбоо зохион байгуулах, эвдэрсэн техник багаж хэрэгслийг засварлах
14.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүлэг	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах бүлэг	Гамшиг, ослын үед Монгол Улсын хэмжээнд онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, учирч болох кибер халдлагаас хамгаалах, хариу арга хэмжээ авах
		Харилцаа холбооны бүлэг	Гамшиг, ослын үед Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, гамшгаас хамгаалах алба, штаб, шуурхай бүлгийн удирдлагын байр, мэргэжлийн ангийг найдвартай харилцаа, холбоогоор хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөтгөх, гэмтэл саатлыг засварлах, сэргээн босгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх
		Зарлан мэдээллийн бүлэг	Гамшиг, ослын үед холбогдох албан тушаалтны шийдвэрээр харьяа нутаг дэвсгэрт харилцаа холбооны бүх төрлийн сувгаар зарлан мэдээлэл дамжуулах, зарлан мэдээлэх технологийн шинэчлэлтийг зохион байгуулах

15	Цацраг, хими, биологийн хариу арга хэмжээ, хяналтын бүлэг	Цацрагийн хэсэг	Гамшиг, ослын голомтод цацрагийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, цацрагийн түвшний хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх
		Химийн хэсэг	химийн тандалт явуулах, үнэлэлт өгөх, хяналтыг хэрэгжүүлэх, химийн бодис, аюулыг тодорхойлох, хэмжилт хийх, эрэн хайх, аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, саармагжуулах ба идэвхгүйжүүлэх, ариутгал цэвэрлэгээ хийх
		Биологийн хэсэг	Биологийн аюулыг тодорхойлох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх
16	Тэсэрч дэлбэрэх бодисын бүлэг	Тэсэлгээний бодис илрүүлэх хэсэг	Тэсэрч дэлбэрэх бодисыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах, аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэх
		Тэсэлгээний бодис аюулгүй болгох хэсэг	Тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох
17	Хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бүлэг	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хэсэг	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх
		Зоонозын өвчинтэй тэмцэх хэсэг	Хүний гоц халдварт өвчний хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх
18	Зам, гүүрний засварын бүлэг		Гамшиг, ослын улмаас нурсан, эвдэрсэн зам, гүүр засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх
19	Автотээврийн хангалт бүлэг	Автотээврийн хангалтын хэсэг	Гамшгийн үед автотээврийн хангалтыг зохион байгуулах
		Тээврийн хэсэг	Нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшиг, ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх
20	Төмөр замын бүлэг	Төмөр зам зохион байгуулалтын хэсэг	Төмөр замын ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед аврах ажиллагаа зохион байгуулах, гамшгийн үед ачаа тээвэр гүйцэтгэх
		Төмөр замын засварын хэсэг	Галт тэрэгний хөдөлгөөнийг сэргээх, засварлах, мэргэжлийн бусад ажлуудыг гүйцэтгэх
21	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Нисэх буудлын аюулгүй байдлын хэсэг	Агаарын хөлгийн хөөрөх, буух үеийн аюулгүй байдлыг хангуулах, гамшиг, ослын үед нислэгийн бүсэд аврах, хор уршгийг арилгах, гал түймрийг унтраах, нислэгийн зурвасыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах

		Нисэх буудлын зохицуулалтын хэсэг	Гамшгийн үед агаарын хөлгөөр хүн, ачаа тээврийг зохион байгуулах
22		Улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хамгаалах бүлэг	Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед онц чухал объектуудыг хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ
23	Харуул хамгаалалтын бүлэг	Харуулын бүлэг	Гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлсэн иргэдийн болон гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулж байгаа штаб, бүлэг, байгууллагуудын харуул хамгаалалтыг хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, харуулын үүрэг гүйцэтгэх
		Хамгаалалтын бүлэг	
24		Барилга байгууламж, дэд бүтцийн хяналтын бүлэг	Гамшиг, ослын үед Монгол Улсын хэмжээний онц чухал дэд бүтэц бүхий байгууллагууд болон иргэний барилгуудын хяналтыг зохион байгуулах
25		Хот хаягдал цэвэрлэх, тээвэрлэх бүлэг	Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учирсан эсхүл болзошгүй аюул үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тархалтыг зогсоох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах
26		Анхны тусламжийн дэмжлэгийн бүлэг	Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
27		Эрэн хайх, аврах, гал унтраах дэмжлэгийн бүлэг	Гамшиг, ослын үед эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
28		Ухуулга, сурталчилгааны дэмжлэгийн бүлэг	Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах
29	Дэмжлэг үзүүлэх бүлэг		Гамшгийн үед гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхээс бусад хүн хүчний дэмжлэг туслалцаа үзүүлэх, суралцаж буй чиглэлээр дэмжлэг үзүүлж оролцох
			Бараа бүтээгдэхүүн тээвэрлэх, хүргэх, хамгаалалт зохион байгуулахад хүн хүчний дэмжлэг үзүүлэх
			Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
30		Хүүхэд хамгааллын бүлэг	Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах

#### Дөрөв. Мэргэжлийн ангийн зохион байгуулалт

4.1.Сум, дүүргийн Засаг дарга, тосгоны Захирагчийн захирамжаар ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийг байгуулж, даргаар тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Тосгоны захирагчийн Ажлын албаны дарга буюу түүнтэй дүйцэхүйц албан тушаалтан байна.

4.2.Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг хүн амын тооноос хамаарч сум, тосгон, дүүрэгт дараах байдлаар байгуулна.

4.2.1.хүн, амын тоо нь 5.000 хүртэл сум, дүүрэг, тосгонд 50-аас доошгүй хүнтэй,

4.2.2.хүн, амын тоо нь 5.000-10.000 сум, дүүрэг, тосгонд 75-аас доошгүй хүнтэй,

4.2.3.хүн амын тоо нь 10.000-15.000 сум, дүүрэг, тосгонд 95-аас доошгүй хүнтэй,

4.2.4.хүн амын тоо нь 15.000-аас дээш сум, дүүрэг, тосгонд 115-аас доошгүй хүнтэй байхаар тус тус байгуулна.

- 4.2.5.бүлэг 10-аас доошгүй хүнтэй, хэсэг 5-аас доошгүй хүнтэй, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн анги тус бүр 150-аас доошгүй хүнтэй байна.
- 4.2.6.дэмжлэг үзүүлэх бүлэгт их, дээд сургууль, коллеж, МСҮТ зэрэг байгууллагууд орно. Бүх шатны сургуулийн захирлын тушаалаар дэмжлэг үзүүлэх бүлэг байгуулагдана. Дэмжлэг үзүүлэх бүлэг нь ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтэцтэй байна.
- 4.2.7.дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн сургалт, үйл ажиллагаа нь тухайн сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан байна.
- 4.3.Хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчдын тоо 50 ба түүнээс дээш тохиолдолд ерөнхий зориулалтын болон тусгай зориулалтын мэргэжлийн ангийг байгуулж, гүйцэтгэх чиг үүрэгт нь сургаж дадлагажуулах бөгөөд онцгой байдлын байгууллагаас мэргэжил, арга зүйн болон мэргэжлийн ангийг сурган дадлагажуулахаар тусламж авна.
- 4.5.Мэргэжлийн анги нь өдөр тутмын үйл ажиллагаандаа гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох сургалт дадлагыг бие даан зохион байгуулж, ажилтан, албан хаагчдаа сургаж дадлагажуулж, бэлэн байдлыг нь хангуулна.
- 4.6.Бүх шатны Засаг дарга, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь мэргэжлийн ангийн дадлага, сургалт, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг жил бүрийн орон нутгийн төсөв, байгууллагын төсөвт тусган батлуулж хэрэгжилтийг хангана.
- 4.7.Гамшгаас хамгаалах албаны мэргэжлийн анги нь тухай салбарын чиглэлээр гамшгийн үед дэмжлэг үзүүлэх зориулалтай байна . Гамшгаас хамгаалах албаны мэргэжлийн анги нь үүрэг зориулалтаас хамаарч хүний тоо харилцан адилгүй байж болно. Тус мэргэжлийн ангийг Гамшгаас хамгаалах албаны даргын тушаалаар томилно.
- 4.8 Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн ангийн гишүүд нь гамшиг, ослын голомтод гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааврыг чанд сахиж, мөрдөх, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадалд суралцсан байна.

#### Тав. Байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг

##### 5.1.Бүх шатны Засаг дарга дараах үүрэг хүлээнэ:

###### А.гамшгийн өмнөх үед:

- 5.1.1.мэргэжлийн ангийг байгуулах;
- 5.1.2.мэргэжлийн ангийг аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;
- 5.1.3.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд мэргэжлийн ангийг оролцуулах;
- 5.1.4.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний дагаж мөрдөх журам, зааврыг батлах;
- 5.1.5.мэргэжлийн ангийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэх дадлагажуулах;
- 5.1.6.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах;
- 5.1.7.гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
- 5.1.8.мэргэжлийн ангид дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зардал, хөрөнгийг шийдвэрлэх, жил бүр орон нутгийн төсөвт тусгаж батлуулах;
- 5.1.9.гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журмын дагуу бэлэн байдлыг шалгах, үнэлэх;
- 5.1.10.үүргээ биелүүлээгүй мэргэжлийн ангийн удирдлага, ажилтан, алба хаагчид хариуцлага тооцох;
- 5.1.11.мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

###### Б.гамшгийн үед:

- 5.1.11.гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг оролцуулах, хуваарилах;
- 5.1.12.гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;
- 5.1.13.гамшгийн голомтод ажиллуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангуулах;
- 5.1.14.мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг нөхөн сэлбэх арга хэмжээ авах;

###### В.Гамшгийн дараах үед:

- 5.1.15.гамшгийн голомтод ажиллуулсны томилолтын зардлыг шийдвэрлэх,
- 5.1.16.гамшгийн голомтод ажилласан мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сэтгэл зүйн болон сэргээн заслын эмчилгээнд хамруулах;
- 5.2.төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага дараах үүрэг хүлээнэ:

###### А.гамшгийн өмнөх үед:

- 5.2.1.мэргэжлийн ангийг түшиглэн байгуулах сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн жагсаалтыг гаргах;
- 5.2.2.мэргэжлийн ангийн алба хаагчдын хээрийн үүргэвчинд байх зүйлсийн жагсаалтыг гаргаж батлах;
- 5.2.3.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний "яаралтай цуглар" дохиогоор ажиллах журмыг боловсруулж тухайн шатны Засаг даргаар батлуулах, хэрэгжилтийг хангах;
- 5.2.4.тухайн мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн судалгааг нэгтгэх;



- 5.2.5.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 5.2.6.гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журмын дагуу бэлэн байдлыг шалгах, үнэлэх, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх;
- 5.2.7.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, заавар зөвлөмж өгөх;
- Б.гамшгийн үед:
- 5.2.8.гамшгийн голомтод мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг гамшгийн нөхцөл байдал, цар хүрээг тодорхойлж цагийн байдлыг үнэлсний үндсэн дээр хуваарилах, удирдлага зохицуулалтаар хангах;
- 5.2.9.мэргэжлийн ангиудын харилцан ажиллагааг зохион байгуулах;
- В.гамшгийн дараах үед
- 5.2.10.мэргэжлийн ангийн үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэх;
- 5.3.гамшгаас хамгаалах Улсын болон орон нутгийн алба, хуулийн этгээдийн дарга (захирал) дараах үүрэг хүлээнэ:
- А.гамшгийн өмнөх үед:
- 5.3.1.мэргэжлийн ангийг байгуулах;
- 5.3.2.мэргэжлийн ангийг аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах;
- 5.3.3.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд мэргэжлийн ангийг оролцуулах;
- 5.3.4.мэргэжлийн ангийг гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд сургаж бэлтгэх дадлагажуулах;
- 5.3.5.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулах;
- 5.3.6.гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх;
- 5.3.7.мэргэжлийн ангид дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зардал, хөрөнгийг шийдвэрлэх, жил бүрийн төсөвтөө суулгах;
- 5.3.8.гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журмын дагуу бэлэн байдлыг шалгах, үнэлэх ;
- 5.3.9.үүргээ биелүүлээгүй мэргэжлийн ангийн удирдлага, ажилтан, алба хаагчид хариуцлага тооцох;
- 5.3.10.гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Б.гамшгийн үед:
- 5.3.11.онцгой комисс, онцгой байдлын байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 5.3.12.гамшгийн голомтод мэргэжлийн ангиар үүрэг гүйцэтгүүлэх, удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 5.3.13.бусад төрөл, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагааг зохион байгуулах;
- 5.3.14.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг амрах байр, цэвэр ус, хоол хүнс, бусад шаардлагатай зүйлсээр хангах;
- 5.3.15.бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангах;
- В.гамшгийн дараах үед:
- 5.3.16.гамшгийн голомтод ажилласан ажилтан алба хаагчид томилт, урамшуулал олгох;
- 5.3.17.гамшгийн голомтод ажилласан мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сэтгэл зүйн болон сэргээн заслын эмчилгээнд хамруулах;
- 5.3.18.мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах, тайлан мэдээг гаргаж онцгой байдлын байгууллагад хүргүүлэх;

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ**

Нэг. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бүтэц.

- 1.1.Мэргэжлийн ангийн удирдлагын бүрэлдэхүүн нь дараах бүтэцтэй байна.
- 1.1.1.мэргэжлийн ангийн дарга;
- 1.1.2.орлогч бөгөөд төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ажилтан;
- 1.1.3.ажиллагаа хариуцсан ажилтан;
- 1.1.4.холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан;
- 1.1.5.аюулгүй байдал хариуцсан ажилтан;
- 1.1.6. эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан;
- 1.1.7.хангалт хариуцсан ажилтан;

1.1.8.дэмжлэг үзүүлэх бүлэг хариуцсан ажилтан.

Хоёр. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1. Мэргэжлийн ангийн дарга:

А.гамшгийн өмнөх үед:

2.1.1.гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх;

2.1.2.жилд 2 удаа мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээ, бие бүрэлдэхүүн, автомашин, техник, тоног төхөөрөмжийн тоог 6 ба 12 дугаар сард мэдээний маягтын дагуу гаргаж, харьяалах онцгой байдлын байгууллагад хүргүүлэх;

2.1.3.мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.1.4.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулах;

2.1.5.мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажиллах бэлэн байдлыг хангуулах;

Б.гамшгийн үед:

2.1.6.холбогдох удирдах албан тушаалтны шийдвэр ийг тодотгож бие бүрэлдэхүүнийг "яаралтай цугларах" дохиогоор цуглуулж тогтоосон хугацаанд заасан байршилд үүрэг гүйцэтгүүлэхээр бэлэн болгох;

2.1.7.гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, шийдвэр гаргах, шуурхай хариу арга хэмжээг төлөвлөх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

2.1.8.дайчилгаагаар хүч нэмэгдүүлж ирсэн бүлэг, хэсгийг чиглүүлэх;

2.1.9.эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

2.1.10.онцгой байдлын байгууллага, шуурхай бүлгийн удирдлага, алба, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох;

2.1.11.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах;

2.1.12.мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хоол, ус, дулаан хувцас байраар хангах;

2.1.13.үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг сэлгэн ажиллуулах, амраах, хүн хүч хэрэгслийн нөөц бүрдүүлэх;

В.гамшгийн дараах үед:

2.1.14.сэргээн босгох арга хэмжээнд оролцох;

2.1.15.хохирлыг тооцох;

2.2.мэргэжлийн ангийн даргын орлогч бөгөөд төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.2.1.мэргэжлийн ангийн даргын эзгүйд түүний үүргийг орлон гүйцэтгэх;

2.2.2.мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2.3.шаардлагатай хүн, хүч техник хэрэгслийн судалгаа гаргах, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

2.2.4.гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль явуулахад шаардлагатай танхим, дадлагын талбай бэлтгэх, бие бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулах;

2.2.5. хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэрэмжлүүлэг, гамшиг, ослын нөхцөл байдал, хор уршгийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдад таниулах, сурталчлах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалаар хангах зэрэг ажлыг зохион байгуулах;

Б. Гамшгийн үед:

2.2.6.гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахад мэргэжлийн ангийн даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах;

2.2.7.гамшгийн голомтод мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

2.2.8.эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

2.2.9.үүссэн нөхцөл байдалд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх;

Б. Гамшгийн дараах үед:

2.2.10.мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах;

2.2.11.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих,

илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

2.3. Ажиллагаа хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.3.1.хүн хүч хэрэгслийг тодотгох, судалгаа авч нэгтгэх;

2.3.2.хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;

2.3.3.бие бүрэлдэхүүнд гамшгийн үед хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар дадлага эзэмшүүлэх;

Б. Гамшгийн үед:

2.3.4.гамшгийн голомтод хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

2.3.5.гамшгийн голомтод харилцан ажиллагааг зохион байгуулах

2.3.6.хүн хүч хэрэгслийг нэмэлтээр дайчлах арга хэмжээг зохион байгуулах;

В.гамшгийн дараах үед:

2.3.7.хүн хүч хэрэгслийг бүртгэх;

2.3.8.хохирлын хэмжээг тогтоох, дээд шатны байгууллагад танилцуулах, тайлагнах;

2.4.холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.4.1.холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.4.2.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж батлуулах, тухай бүр тодотгох;

2.4.3.бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх;

Б. Гамшгийн болон дараах үед:

2.4.4.гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргыг холбоо, мэдээллээр хангах;

2.4.5.дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;

2.4.6.холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх, нөхөн сэлбэх;

2.5.Аюулгүй байдал хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.5.1.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, баталгаажуулах;

2.5.2.хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;

2.5.3.хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;

2.5.4.галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт болон химийн хортой болон аюултай бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлт, объектын харуул хамгаалалтад хяналт тавих;

Б. Гамшгийн үед:

2.5.5.гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;

2.5.6.аврах ажиллагааг эхлэх, дуусах хугацааг тогтоож, аюулгүй бүсэд бие бүрэлдэхүүний амрах нөхцөлийг бүрдүүлэх;

2.5.7.гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний эрүүл мэндэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.8.хүч хэрэгслийг гамшиг, ослын голомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.9.гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлэх.

В. Гамшгийн дараах үед:

2.5.10.мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, аюулгүй байдлыг сайжруулах;

2.6. эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан;

А.гамшгийн өмнөх үед:

2.6.1.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг үзлэг хийх, зааварчилгаа танилцуулах;

2.6.2.эрүүл мэндийн талаар заавар зөвлөмж өгөх, эрүүл мэндийг хамгаалах;

2.6.3.хүн, малын гоц халдварт өвчний голомтод ажиллах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд хамгаалах хувцас хэрэглэл хэрэглэх, ажиллах талаар сургах, зааварчилгаа өгөх;

Б. Гамшгийн болон дараах үед:

2.6.4.гамшиг, осол, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн хүмүүс эрүүл мэндийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.6.5.гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний эрүүл мэндэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

2.6.6.эрүүл мэндийн салбарын дайчилгаа явуулах ажлыг зохион байгуулах, төлөвлөх.

2.7.хангалт хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.7.1.мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, хангалтын төлөвлөгөө боловсруулах,

2.7.2.гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх;

2.7.3.аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах;

Б. Гамшгийн болон дараах үед:

2.7.4.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг байр, цэвэр ус, хоол хүнс, эм, ороох боох материалаар хангах;

2.7.5.голомтод үүрэг гүйцэтгэж байгаа техник, тоног төхөөрөмжийг шатах тослох материалаар хангах;

2.7.6.хочирлын үнэлгээг хийж, мэргэжлийн ангийн даргыг мэдээллээр хангах;

2.7.7.гамшиг, аюул үзэгдэл, ослын хариу арга хэмжээнд зарцуулсан зардал, бараа материалын тайлан гаргаж танилцуулах.

2.8.дэмжлэг үзүүлэх бүлэг хариуцсан ажилтан дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

2.8.1.дэмжлэг үзүүлэх бүлгээр ажиллах боломжтой байгууллагуудыг томилгоожуулан, харилцан ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;

2.8.2.бүлгийн хүн, хүч хэрэгслийн судалгааг гарган тодотгох;

2.8.3.бүлгийн гишүүдийг мэргэжлийн байгууллагатай хамтран сургаж дадлагажуулах;

Б. Гамшгийн болон дараах үед:

2.8.4.бүлгүүдийг нэгдсэн удирдлагаар хангах;

2.8.5.ажлын чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжоор хангах;

2.8.6.бүлгийн гишүүдийн эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх.

Гурав.мэргэжлийн ангийн гишүүний үүрэг:

3.1.мэргэжлийн ангийн гишүүн дараах үүрэг хүлээнэ:

А.гамшгийн өмнөх үед:

3.1.1.гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль, бусад нэгдсэн арга хэмжээнд оролцож өөрийгөө хөгжүүлэх, хувийн бэлэн байдлаа хангах;

3.1.2.хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг ажиллуулах дадлага эзэмшсэн байх;

3.1.3.хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах;

3.1.4.зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшсэн байх;

3.1.5.аюулгүй ажиллагааны зааварчилгааг судлах;

3.1.6.өөртөө болон бусдадаа тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх;

Б.гамшгийн болон дараах үед:

3.1.7.удирдлагын шийдвэрээр гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх;

3.1.8.аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллах;

3.1.9.эрүүл мэнд, сэтгэл зүйн эмчилгээнд хамрагдах;

3.1.10.хувийн бэлтгэлийг хангаж дараагийн томилоот үүрэг гүйцэтгэхэд бэлтгэх.

#### ГУРАВДУГААР БҮЛЭГ

#### МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДАЛ, СУРГАЛТ ДАДЛАГА

Нэг. Мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах арга хэмжээ

1.1.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл, бэлэн байдлыг хангах асуудлыг тухайн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн удирдлага шууд хариуцна.

1.2.Мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлыг хангахад шаардагдах зардлыг тухайн байгууллага хариуцна.

1.3.мэргэжлийн ангийн бэлэн байдлын үзлэгийг батлагдсан удирдамж, журмын дагуу төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага тухайн байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй хамтран холбогдох дүрэм, журмын дагуу жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

Хоёр. Мэргэжлийн ангийн сургалт дадлага

2.1.Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг жилд 2-оос доошгүй удаа төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага хариуцан зохион байгуулна.

2.2. Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургалтыг гамшгаас хамгаалах албаны дарга хариуцах бөгөөд шаардагдах зардлыг шийдвэрлэнэ.

2.3. Сум, дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга хариуцах бөгөөд шаардагдах зардлыг шийдвэрлэнэ.

2.3. Аймаг, сум, нийслэл, дүүргийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, команд-штабын сургуульд мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг оролцуулна.

2.5.Мэргэжлийн ангийн дарга нь гамшгаас хамгаалах сургалт, дадлага, сургуулийг мэргэжлийн ангийн чиг үүрэгт нийцүүлэн жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна. Тухайн сургалт танхимын сургалт (30 хувь), дадлага сургууль (70 хувь) гэсэн бүтэцтэй байх бөгөөд жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ХАНГАЛТ

Нэг. Мэргэжлийн ангийг техник, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ.

1.1.Мэргэжлийн ангийн техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг тухайн шатны Засаг дарга баталж, хэрэгжилтийг хангана.

1.2.Мэргэжлийн ангийн техник, тоног төхөөрөмжийн хангалтад дараах хэрэгслүүд орно:

1.2.1.байгууллагын гамшгийн нөөц (ус, хүнс, хувцас, тоног төхөөрөмж);

1.2.2.цацраг, хими, биологийн тандалт, хяналтын багаж хэрэгсэл /цацраг, хими, биологийн чиглэлээр үүрэг гүйцэтгэх бүлэгт/;

1.2.3.хүн нэг, бүрийн хамгаалах хэрэгсэл

1.2.4.хүн нэг бүрийн хээрийн үүргэвч;

1.2.5.голомтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл бүсийн тэмдэг тэмдэглэгээ;

1.2.6.гал унтраах багаж, хэрэгсэл;

1.2.7.инженерийн техник;

1.2.8.цэвэр, бохир ус болон дулааны шугам засварлах багаж, техник хэрэгсэл;

1.2.9.холбоо, зарлан мэдээлэх хэрэгслүүд, чанга яригч;

1.2.10.хээрийн гал тогоо;

1.2.11.гамшгийн үеийн удирдлагын хөдөлгөөнт болон суурин байр (гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлагыг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор холбоо, мэдээллийн техник хэрэгсэл, бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хөдөлгөөн үйлдэх боломжтой болон суурин байрыг хэлнэ);

1.2.12.хээрийн эмнэлгийн байр, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, ороох боох материал, ариутгалын бодисын нөөц;

1.2.13.гэр, майхан (хоргодох байр);

1.3.Мэргэжлийн анги дараах үндсэн баримт бичгүүдийг хөтөлнө:

1.3.1.мэргэжлийн ангийг байгуулсан тухай тушаал;

1.3.2.бүх төрлийн судалгаа мэдээлэл;

1.3.3.мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөө, тодотгол;

1.3.4.мэргэжлийн ангийн зохион байгуулалтын бүдүүвч;

1.3.5.мэргэжлийн ангийн чиг үүрэг, зориулалтыг тусгасан дотоод дүрэм, журам;

1.3.6.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам;

1.3.7.бие бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын төлөвлөгөө;

1.3.8.сургалт арга зүйн гарын авлага;

1.3.9.мэргэжлийн ангийн техник, багаж хэрэгслийн нөөц, хангалтын тооцоо;

1.3.10.гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, штабын дадлагад оролцсон тухай тэмдэглэл;

1.3.11.мэргэжлийн ангийн бэлэн байдлыг шалгасан, шалгуулсан тухай тэмдэглэл;

- 1.3.12.мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажилласан тухай тэмдэглэл;
- 1.4.Мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгийг тухайн мэргэжлийн ангийн даргын томилсон албан тушаалтан хөтөлнө.
- 1.5.Мэргэжлийн ангийн хөтлөх баримт бичгүүдийн бүрдэлд төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангана.
- 1.6.Гамшгийн үеийн эрэн хайх, аврах үйл ажиллагааны санхүүжилт нь гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд зааснаар зохицуулагдана.

#### Хоёр. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн санхүүжилт

- 2.1.Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:
  - 2.1.1.гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана. Мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т заасны дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж заасны дагуу шаардагдах зардлыг шийдвэрлэнэ.
  - 2.1.2.гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 заасны дагуу төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардлаа өөрөө хариуцна.
  - 2.1.3.олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн болон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгөөр санхүүжүүлж болно.
- 2.2.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн нь гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 37.1.5 дахь хэсэгт заасны дагуу томилолтын зардал авна.
- 2.3.Гамшгийн хор уршгийг арилгах ажилд оролцсон иргэн, сайн дурынхан гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2, 37 дугаар зүйлийн 37.1.5-д заасан буцалтгүй тусламж, цалин, хөлс, томилолтын зардлыг авах эрхтэй.
- 2.4.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үедээ бэртэж, гэмтсэн мэргэжлийн ангийн ажилтныг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, хуулийн этгээд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас тус тус шийдвэрлэнэ.
- 2.5.Гамшиг, осол дээр хүний амь нас, эд хөрөнгийн авран хамгаалж, онцгой гавьяа байгуулсан ажилтан, алба хаагчдад мэргэжлийн ангийн даргын саналыг үндэслэн төрийн шагнал, салбарын шагналаар шагнаж болно.

#### ТАВДУГААР БҮЛЭГ

##### МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

###### Нэг. Гамшгийн үеийн мэргэжлийн ангийн үйл ажиллагаа

- 1.1.Мэргэжлийн ангийн дарга болон холбогдох удирдах албан тушаалтны шийдвэрээр Тухайн шатны Засаг дарга, гамшгаас хамгаалах албаны дарга, Хуулийн этгээдийн дарга, захирагчийн боловсруулсан зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журмын дагуу, бие бүрэлдэхүүнийг гамшиг, осол үүссэн үед "Цуглар", гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулийн үед "Яаралтай цуглар" дохио өгч ажиллуулна.
- 1.2.Аймаг, сумын Засаг дарга, тосгоны Захирагч серин дохио буюу дуут дохиогоор мөн утсан болон биет холбоогоор цуглах арга хэмжээг тусгай журам боловсруулан журамлана.
- 1.3.Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохио авсан даруйдаа тогтоосон хугацаанд, заасан байршилд томилгоожсон техник, багаж хэрэгсэлтэйгээр цуглана.
- 1.4.Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг оролцуулахдаа мэргэжлийн ангийн удирдлага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
  - 1.4.1.гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэх тухай удирдлагын шийдвэрийг тодотгох;
  - 1.4.2.гамшиг, ослын хор хөнөөл, хүрээ, газар нутгийн онцлог, цаг агаарын болон бусад нөхцөл байдлыг үнэлэх;
  - 1.4.3.өөрийн хүч хэрэгсэл, бусад хүч хэрэгслийн чадавхыг үнэлэх;
  - 1.4.4.гамшиг, ослын голомтод хүрэлцэн очих зам, газар зүйн солбицол, хөдөлгөөн үйлдэх дарааллыг тогтоох;
  - 1.4.5.мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хамгаалах хэрэгсэл, ус, хоол хүнсний хангалтыг тооцох;
- 1.5.Гамшиг, ослын голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг явуулахдаа доорх хүчин зүйлийг тооцно. Үүнд:
  - 1.5.1.аврах, хор уршгийг арилгах ажиллагааны дарааллыг тогтоох, ажиллагааг идэвхтэй, тогтвортой, тасралтгүй зохион байгуулах;
  - 1.5.2.үүссэн нөхцөл байдал, гамшигтай тэмцэх хариу арга хэмжээний үр дүнг орон нутгийн онцгой байдлын байгууллага, шуурхай бүлгийн удирдлагад мэдэгдэх;

- 1.5.3. тандалтын бүлэг болон бусад бүлгүүдтэй мэдээлэл солилцох, нөхцөл байдлыг нарийвчлан үнэлэх;
- 1.5.4. бусад төрөл, мэргэжлийн анги, бүлэгтэй харилцан ажиллагааг зохион байгуулах;
- 1.5.5. гэнэт үүссэн нөхцөл байдалд шуурхай хариу арга хэмжээ авах;
- 1.5.6. нэмэлт хүч хэрэгсэл шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд мэдэгдэх, шуурхай арга хэмжээг зохион байгуулах;
- 1.5.7. дайчилгаагаар хүч нэмэгдүүлж ирсэн бүлэг, хэсгийг чиглүүлэх;
- 1.5.8. бие бүрэлдэхүүний амь нас эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдүүлэх;
- 1.5.9. аврах ажиллагааг эхлэх, дуусах хугацааг тогтоож, бие бүрэлдэхүүний амрах нөхцөлийг бүрдүүлэх;
- 1.5.10. нуранги, цахилгаан, дулааны шугамын эвдрэл, цацраг, химийн хордолт, гал түймэр, халдварт өвчин зэрэг аюулт үзэгдэл, ослын голомтын хорио цээрийн болон хязгаарлалтын бүсэд хийгдэх тэмдэглэгээ, хөдөлгөөн үйлдэх зам, гарц, дараалал, химийн бодисын тархалт, цацраг идэвхт бодисын дээд, доод хязгаарын тун, бусад нөхцөл байдлыг тооцох;
- 1.5.11. гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн талаар тайлан бэлтгэж, удирдлагад танилцуулах;
- 1.5.12. хохирлыг тооцох;
- 1.6. Мэргэжлийн ангийн дарга дараах үзүүлэлтийг тусгасан шийдвэрийн зураг хөтөлнө.
  - 1.6.1. гамшиг, осолд өртсөн газар нутаг болон голомтын, сэжигтэй, эрүүл бүсийн хил хязгаар;
  - 1.6.2. үүссэн нөхцөл байдал, үүрэг гүйцэтгэж байгаа хүч хэрэгслийн мэдээлэл;
  - 1.6.3. мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн боломж;
  - 1.6.4. нэмэлтээр хүч хэрэгслийг татан байршуулах тооцоо;
  - 1.6.5. хохирлын мэдээлэл зэргийг тусгана.


#### Хоёр. Аюулгүй ажиллагаа

- 2.1. Аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн ангийн гишүүд нь гамшиг, ослын голомтод гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааврыг чанд сахиж, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадалд суралцсан байна.
- 2.2. Мэргэжлийн ангийн удирдлага нь голомтод гүйцэтгэх чиг үүрэгтэй нь холбогдуулан бие бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгч, гарын үсэг зуруулж, хяналт тавьж ажиллана.
- 2.3. Хүйтний улиралд үүрэг гүйцэтгэх үед харагдах орчин хязгаарлагдсан, шөнийн цагаар гэрэлтүүлэггүй тохиолдолд үүрэг гүйцэтгэлтийг шууд зогсооно.
- 2.4. Голомтын бүс дэх аюултай цэг, байршлыг тогтоож, тэмдэгжүүлнэ. Нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, аврах ажиллагааны техник, багаж хэрэгслийг голомт руу хүргэх, гаргахдаа урьдчилан тогтоосон чиглэл, маршрутаар явна.
- 2.5. Аврах ажиллагааны зориулалтын техник, багаж хэрэгслийг ажиллуулах дадлага чадвар эзэмшээгүй хүнийг голомт руу нэвтрүүлэхийг хориглоно.
- 2.6. Цацраг, хими, биологийн аюултай бүсэд ажиллах мэргэжлийн ангийн гишүүдийг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.
- 2.7. Цацраг, химийн бодис тархсан голомтод ажиллах хугацаа дууссан эсвэл хордсон мэргэжлийн ангийн гишүүдийг ариутгал, халдваргүйтгэл хийж, голомтоос гаргаж, дараагийн бүлгийг голомт руу оруулна.
- 2.8. Бүлэг, хэсгийн дарга нар голомтын гарц дээр ээлж хүлээлцэх бөгөөд ээлж хүлээлгэн өгөх дарга дараагийн даргад нөхцөл байдлыг танилцуулж, мэдээлэл солилцоно.
- 2.9. Бүлэг, хэсгийг голомтоос гарсны дараа амраах бөгөөд шаардлагатай тохиолдолд дараагийн ажиллагаанд бэлтгэнэ. Голомтод ажилласан техник, багаж хэрэгсэлд засвар үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэл хийж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслийг сольж нөхөн хангалт хийнэ.
- 2.10. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн А/338 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг чанд сахин биелүүлж ажиллана.


#### Гурав. Бусад

- 3.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь мэргэжлийн ангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх саналаа онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад бичгээр ирүүлнэ.—
- 3.2. Энэхүү дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол "Төрийн албаны тухай хууль", "Зөрчлийн тухай хууль"-д заасан хариуцлага оногдуулна.

Зураг 1. Мэргэжлийн ангийн бүтэц



Зураг 2. Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүтэц



Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээ өгөх маягт

**МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭНИЙ ХУУДАС**

..... аймаг ..... сумын мэргэжлийн анги

№	Мэргэжлийн ангид томилогдсон албан тушаалтны байгууллагын нэр	Мэргэжлийн ангийн бүлэг, хэсгийн тоо	Томилогдсон хүний тоо	Ашиглаж байгаа техникийн нэр, тоо	Ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл



1	Засаг даргын тамгын газар		6	Зөөврийн усны машин -1	Үлээгч аппарат -2
2	Эрүүл мэндийн газар		12	Экскаватор -1	Зөөврийн цахилгаан үүсгүүр -1
3	Боловсролын газар		3		
4	...				
5	...				
6	...				
7					
8	НИЙТ				
..... сум/аймаг, дүүрэг, нийслэл/-ийн мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэлт					
№	Гамшиг, ослын нэр	Үүрэг гүйцэтгэсэн он, сар, өдөр	Явсан дуудлагын тоо	Аварсан эд хөрөнгө	Аварсан хүний тоо
1	Ой хээрийн түймэрт		2	1,2 тэрбум	1
2	Цас шаварт суусан		2	8 сая	4
3	Төөрсөн		3	-	2
	НИЙТ				
<b>Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:</b> Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг ой хээрийн түймэр унтраах, эрэн хайх аврах багаж хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх ...					

ХЯНАСАН: .....

НЭГТГЭСЭН:.....